



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын III их  
наадмын дугуйн аялалын тэмцээн  
зохион байгуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын III их наадмын тэмцээнийг 2014 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Найрамдал зуслангийн замд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 602.000 /зургаан зуун хоёр/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн иргэдийн спортын наадмын зардлаас гаргахыг нягтлан бодох О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнийг урьдчилан бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500099